

Монгол Улс, АНУ-ын Хооронд Дипломат Харилцаа Тогтоосны 30 жилийн Ойд Зориулсан Эрдэм Шинжилгээний Бага Хурлын эмхэтгэлд зориулав

Улаанбаатар хот, Гадаад харилцааны яам,
“Зөвшилцөл” танхим, 2017 оны 1 дүгээр сарын 27

Хэлэлцүүлгийн тэмдэглэл:

Д.Уламбаяр: Монгол, АНУ-ын дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн амгаланг айлтгаж байна. Илтгэгчид их сонирхолтой илтгэлүүд тавилаа. Монгол, АНУ-ын харилцаа нь Монгол Улсын “гуравдагч хөршийн бодлого”-ын хүрээнд хөгжиж ирсэн бөгөөд манай улс “гуравдагч хөршийн бодлогыг” 2010 онд Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалдаа, 2011 онд Гадаад бодлогын үзэл баримтлалдаа тус тус тусган тунхагласан билээ. Үүнд юуны өмнө “гуравдагч хөрш” гэдэг нь өндөр хөгжилтэй болон ардчилсан орон гэж томъёолсон. Шинжлэх ухааны үүднээс нь дүгнэвэл манай энэ бодлого 2 үе шаттай явагдсан. Нэгдүгээрт, 1990-ээд оны гуравдагч хөршийн бодлого. 1994 оны Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал болон Аюулгүй байдлын үзэл баримтлалд хөгжингүй улсуудын эдийн засгийн бодит ашиг сонирхлыг Монгол Улсад бий болгоно гэж тодорхойлсон байдаг. 1990-ээд он гэдэг бол дэлхийн бодлого, олон улсын харилцаанд нэг туйлт дэг журам, АНУ-ын тэргүүлэл үйлчилж байсан үе байсан. Харин өнөөдрийн “гуравдагч хөршийн бодлого” нь олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцын хүрээнд хэрэгжиж байгаа юм. Одоогоор яах ч аргагүй манай

хоёр хөршүүдээр тэргүүлүүлсэн олон улсын харилцааны олон туйлт шинэ дэг журам үүсэн тогтож байна. Ийм үед хоёр хөршүүдтэйгээ тэнцвэртэй харилцах бодлого, гурвалсан хөршийн бодлогыг хэрхэн “гуравдагч хөршийн бодлого”-той хүчний тэнцвэр, эрх ашгийн тэнцвэрийг барьж бодлого явуулна гэдэг чухал боллоо.

1990 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэрээ АНУ, Монгол Улсын хувьд “гуравдагч” хөрш байж болох үзэл санааг анхлан гаргасан гэж үздэг. 1990 оны 7 дугаар сарын 26-нд Ж.Бейкер ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнгтэй өргөтгөсөн хэлэлцээ хийх үеэрээ: **“БНМАУ хоёр хөрштэй. АНУ тэдний аль нэгтэй харилцахдаа танай харилцаанд сэв суулгахыг боддоггүй. Танай улс АНУ-ыг оролцуулж гурван том улстай сайн хөршийн харилцаатай байж болох юм”**. (1) гэж тэмдэглэн хэлжээ. Энэ үе бол Монгол Улсад анхны ардчилсан сонгууль явагдаж дуусаад удаагүй байв. Ж.Бейкер айлчлалынхаа өмнө 1990 оны 7 дугаар сарын 13-нд Вашингтонд суугаа Элчин сайд Г.Нямдоотой уулзахдаа: “...танай сонгууль ямар нэг будлиангүй, зохих ёсоор явагдвал миний бие айлчлахад бэлэн байна” гэж онцлон тэмдэглээд будлиан гарвал айлчлах бололцоогүй гэдгээ онцлон тэмдэглэж байжээ. (2) Харин Монгол Улсад сонгууль шударга, ардчилсан зарчим дээр, олон улсын ажиглагчдын оролцоотойгоор явагдсан билээ. Ж.Бейкер *“The Politics of Diplomacy”* номондоо сонирхолтой зүйл тэмдэглэсэн нь түүний улс төрийн гол зөвлөхүүд болох Деннис Росс, Боб Зэллик нар түүнийг Монголд айлчлуулахгүй, шууд Москвад очихоор зохион байгуулсан байжээ. Тэд Монголд дургүйдээ биш, хоёр өдрийн өмнө ч гэсэн гэртээ эрт очихыг бодож тэгж төлөвлөж байсан гэжээ. (3) Тэрбээр Монголд айлчлан ирээд ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнгтэй уулзахдаа: “...хүмүүсийн бодол янз бүр юм. Сая намар танай оронд айлчлах тухай ярилцаж эхлэхэд зарим хүн хоёрхон сая хүнтэй Монголд очих хэрэггүй, заавал ач холбогдол өгөөд байх шаардлагатай орон биш гэж надад хэлж байсан. Тийм хүмүүстэй би санал нийлээгүй. Манай хоёр орон 70 жил бие биеэ мэдэхгүй, танихгүй хүмүүс шиг явлаа. Бид үүнийгээ одоо цэгцлэх хэрэгтэй. Ардчиллыг сонгож авсан улс оронтой ойр дотно байх нь бидний сонирхолд нийцэж байгаа юм. Энэ бол бусад улс гүрэнд түгээх тодорхой илгээлт юм” гэж ярьж байжээ. Өргөтгөсөн

хэлэлцээний дараа Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбаттай уулзахдаа Ж.Бейкер бээр хэлэхдээ АНУ нь ЗХУ, БНХАУ-тай өрсөлдөж Монголд нөлөө олохыг эрмэлзээгүй, Монгол Улс шууд хоёр хөрш оронтойгоо “дээд зэргийн” сайн харилцаатай байх нь маш чухал гэж тэмдэглээд ардчилал, чөлөөт зах зээл бол ард түмнүүдийн сайн сайхан байдал, олон улсын тогтвортой байдлыг дээд зэргээр хангадаг гэдэгт АНУ итгэдэг гэж цохон дурдаж байжээ. П.Очирбат АНУ-тай харилцаагаа хөгжүүлэх нь Монгол Улсад стратегийн ач холбогдолтой, аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангах, тусгаар тогтнолоо бэхжүүлэх ач холбогдолтойг тэмдэглэсэн байна. Мөнхүү айлчлалын үеэр Сайд нарын Зөвлөл дарга Ш.Гунгаадоржтой уулзахад тэрбээр АНУ-тай харилцаа хөгжүүлэх нь зөвхөн цаг хугацааны асуудал биш, алс хэтийн, холын түнш байлгах зорилттой байгааг дурдаад, өөрөөр хэлбэл АНУ манай улсын хувьд гуравдагч том түнш бий болж байна гэж хэлэхэд Ж.Бейкер “...би ч мөн иймэрхүү зүйл хэлж байсан. Би энэ л тухай хэлсэн” гээд АНУ-ын нэг зүйр үг, тухайлбал, «*Great minds think alike*» буюу “Аугаа хүмүүс адилхан сэтгэдэг” гэдгийг иш татаж байсныг хэлэлцээнд оролцож байсан ГЯЯ-ны тухайн салбар хариуцсан орлогч сайд Х.Олзвой дурсан бичсэн байдаг. (4)

Ж.Бейкер эцэг Ж.Бушийг Ерөнхийлөгч байх үед 1989-92 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга, 1992-93 онд Цагаан Ордны Тамгын газрын даргын албыг хашиж байсан юм. Тиймээс хүү Ж.Бушийн Монголын талаарх байр суурь бол залгамж шинжтэй байсан гэж үзэж болохоор байдаг.

1998 оны 5 дугаар сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайт Монголд айлчлал хийх үеэрээ УИХ-ын Танхимд үг хэлэхдээ: «АНУ алс хол оршдог ч Монгол Улс нь ардчиллын үнэт зүйлсийг дээдэлж, нээлттэй эдийн засгийг тууштай баримталдагийнхаа хувьд **хөрш айлдаа** ирсэн мэт ойр дотно сэтгэгдэл төрж байна» (5) гэсэн байна.

2004 оны 7 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бушийн урилгаар тус улсад ажлын айлчлал хийж, төгсгөлд нь гаргасан Хамтарсан Мэдэгдэлд: «...**ардчилсан хоёр орны хооронд хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэлийн шинэ**

эрин үеийг зарлан тунхаглав). (6) АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар тус улсад 2005 оны 11 дүгээр сарын 21-нд албан ёсны айлчлал хийх үеэрээ Төрийн ордны их Танхимд үг хэлэхдээ: *«Албаа хашиж байхдаа Монголд айлчилсан Америкийн анхны Ерөнхийлөгч болж байгаадаа их баяртай байна. Америк орон танай “гуравдагч хөрш” гэдгээрээ бахархдаг билээ»* (7) гэж онцлон тэмдэглэсэн билээ. Айлчлалын үр дүнд гаргасан Хамтарсан Мэдэгдэлд: *«... Ардчилсан хоёр орны хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэлийн удирдах зарчмыг тодорхойлж, цар хүрээг нь өргөтгөхөөр тохиров»* гэжээ. (8)

2011 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АНУ-д ажлын айлчлал хийж, Ерөнхийлөгч Барак Обаматай уулзахад АНУ-ын төрийн тэргүүн хэлэхдээ: *«Манай хоёр орны харилцаа стратегийн түншлэлийн хүрээнд жилээс жилд хөгжиж байгаад би сэтгэл хангалуун байдаг. АНУ Монгол Улсын хувьд гуравдагч хөрш болж байдагтай баяртай байдаг»* гэж дурдахын хамт хоёр тал Хамтарсан мэдэгдэлдээ: Монгол Улс, АНУ 2004, 2005, 2007 онуудад гаргасан мэдэгдлүүддээ дурдагдсан хамтын ажиллагааны зарчмуудыг дахин нотлов.

Бүр 1944 оны 7 дугаар сард АНУ-ын Дэд Ерөнхийлөгч Хенри А.Уоллес Монголд айлчлахад дагалдаж ирсэн, хожим америкийн нэрт монголч эрдэмтэн болсон О.Латимор 1949 онд туурвисан “Ази дахь шийдэл” бүтээлдээ: *«Монголыг гуравдагч орны статустай болгох нь (онцлов Д.У) Америкийн ашиг сонирхол болохсон билээ. Гэтэл энэ улс тусгаар тогтносон уу гэсэн эргэлзээ гарган Монголыг НҮБ-ын гишүүн болгохын эсрэг санал өгч алдаа хийж байна... одоо Монгол коммунистуудын захиргаатай Орос, коммунистуудын хяналттай Хятадын дунд оршиж байна. Ийм нөхцөлд Хятад, Оросын хилийн бүсэд 600 мянган хүн ам, газар нутагт нь оршиж буй энэ орны хувьд ач холбогдол өгөх нь Америкийн бодлогын хувьд давуу тал болохсон...»* (9) гэж тодорхой бичиж байжээ.

Гуравдагч хөршийн бодлогыг аль улстай илүү их худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллаж байгаагаар нь тооцон авдаг хандлага

байдаг ч гуравдагч хөршийн бодлого бол цэвэр улс төрийн чиг шугам юм.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд хэрэг дээрээ «гуравдагч хөрш»-тэй болж, түүний эрхзүйн үндсийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой **«Иж бүрэн түншлэл»**, 2010 онд **«Стратегийн түншлэл»**, 1999 онд БНСУ-тай **«Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл»**, 2006 онд **«Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл»**, 2011 онд **«Иж бүрэн түншлэл»**, 2004, 2005 онд АНУ-тай **«хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэл»**, 2007 онд 2004 онд Канадтай **«Өргөн хүрээтэй түншлэл»**, 2005 онд Турк Улстай **«Иж бүрэн түншлэл»**, 2007 онд Австрали Улстай **«Өргөтгөсөн түншлэл»**, 2007 онд Казахстантай **«Өргөн хүрээтэй түншлэл»**, 2008 онд ХБНГУ-тай **«Иж бүрэн түншлэл»**, 2011 онд **«Стратегийн түншлэл»**, 2009 онд Энэтхэгтэй **«Иж бүрэн түншлэл»**, 2015 онд **«Стратегийн түншлэл»**, 2011 онд **«Стратегийн түншлэл»**, Украинтай **«Олон талтай хамтын ажиллагааны түншлэл»**, 2013 онд ЕХ-той **«Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»**-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулав.

2012 оны 9 дүгээр сарын 17-нд Нью-Йорк хотноо батлагдсан Аюулгүйн зөвлөлийн байнгын таван гишүүн Монгол Улсыг цөмийн зэвсэггүй бүс хэмээн батлан, бичиг дээр буулгасан явдалд АНУ-ын үүрэг хамгийн их нөлөөлсөн.

Ерөнхийлөгчийн санал болгосон “байнгын төвийг сахих” статус нь хоёр хөршийн анхаарлыг нэлээд татсан. Жишээ нь, БНХАУ-ын судлаачид “байнгын төвийн сахих статус нь АНУ-ын заавар зөвлөмжийн дагуу гарсан байж магад” хэмээн хоёр ч удаа өөрсдийн илтгэлүүд дээр дурдсан. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри 2016 оны 6 дугаар сарын 5-нд Монголд Улсад нэг өдрийн айлчлал хийсэн билээ. Тэрбээр Монгол Улсыг ардчилал, хүний эрх харьцангуй хязгаарлагдмал, чөлөөт хэвлэл хяналттай, авторитет дэглэмтэй хоёр хөрштэй нь харьцуулаад үлгэр жишээ болохуйц “ардчилалын баянбүрд” (oasis of democracy) (10) хэмээн онцолсон нь Монгол Улс ардчиллын оройд гарчихсан гэсэн үг биш нь мэдээж билээ. Жон Керри

айлчлалын үеэр Шангри-Ла зочид буудалд монголын залуу манлайлагч нарын төлөөлөлтэй уулзаж харилцан ярилцсан нь анхаарал татав. Ярилцлагын үеэр залуус Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан Монгол Улс төвийг сахих бодлогын тухайд АНУ-ын санаа бодол ямар байгааг сонирхжээ. Жон Керри хариулахдаа: «Тиймээ, төвийг сахина гэж чухам юуг хэлж байгаагаас (олон зүйл) хамаарна. Өөрөөр хэлбэл, юуны учир, ямар зүйлийн талаар та төвийг сахих вэ гэдгээс л хамаарна гэсэн үг юм. Хүний эрхийн талаар би та бүгдийг битгий төвийг сахиасай гэж хүсэх байна. Ардчиллын тухайд би та бүхнийг битгий төвийг сахиасай гэж хүсч байна. Гэхдээ, хэрэв та бүхэн хэсэг бүлэг улс хоорондын тодорхой сөргөлдөөний тухайд төвийг сахих гэж байгаа бол хүний гараар могой бариулах маягийн зарим нэг зүйл рүү чирэгдэн орох шаардлагагүй. Энэ нь төвийг сахих гэж чухам юуг хэлэхээс хамаарна. Миний бодлоор хэн байсан билээ дээ? Данте (Дундад зууны үеийн Италийн гүн ухаанч, яруу найрагчийг хэлсэн болов уу Д.У) бичиж байсан шиг санагдаж байна. Аугаа их ёс суртахууны хямралын үед гол нь төвийг сахиж амиа хоохойлоод тээнэгэлзэн суусан тэдгээр хүмүүс тамын тогооны хамгийн халуун бугшсан ангал руу ордог тухай өгүүлсэн байдаг. Зөв биз? Өнөөдөр та бүхэн тамд итгэхгүй байж болно, та бүхэн диваажинд итгэхгүй байж болно, ер нь юунд ч итгэхгүй байж болно. Харин цэвэр ёс суртахууны асуудлуудын үүднээс авч үзвэл та бүхэн ёс суртахууны луужинтай байх хэрэгтэй нь ойлгомжтой болов уу. Тиймээс хэрэв та ёс суртахууны луужингаа алдвал та бүхэн улс орноо алдана, та эдлэх эрхээ алдана, та эрх чөлөөгөө алдах хамгийн их эрсдэлтэй. Учир иймээс хаана төвийг сахих, төвийг сахихыг хэрхэн ойлгож тодорхойлохоос үүдэн болгоомжтой хандаасай гэж хэлмээр байна.

Бас нэг жишээг та бүхэнд товч хэлье. Асад Сирид ард түмнийхээ талаар явуулж буй үйлдлийг хараад ямар ч улс төвийг сахина гэж би бодохгүй байна. Энэ бол нэг жишээ юм. Төрлөөр устгахын тухайд ч хэн ч төвийг сахиж чадахгүй байх гэж бодож байна. Цэрэгжсэн хүүхдүүдийн тухайд ч хэн нэгэн төвийг сахиж чадахгүй. Хүний наймааны тухайд ч мөн адил хэн ч төвийг сахиж чадахгүй болов уу. Үүнийг л би ёс суртахууны луужин баримжаа гээд байгаа юм шүү дээ. Эдгээр зүйлсийн тухайд ямар нэг мэдрэмж төрөх нь хүний ухамсрын

зүй ёсны хэрэгцээ шаардлага байхад эдгээр зүй бус үйлдлүүдийн талаар санаа бодлоо илэрхийлэхгүй, ёс суртахууны луужин баримжаагаа барихгүй харин ч холдуулаад амьдралдаа зүгээр л мөрөө хөөгөөд явж болохгүй биздээ» (11) гэж маш тодорхой байр сууриа илэрхийлсэн байна.

Энэ нь Монгол Улс АНУ-ын талыг сонсон зөвлөмжийн дагуу хийсэн гэдэг нь худал болохыг баталсан хэрэг юм. Бидний гадаад бодлогын хүрээнд нэгэн том амжилт гаргасан зүйл нь өнгөрсөн оны АСЕМ-ийн уулзалт юм. Тэгэхдээ энэ уулзалтаар бид гуравдагч хөршийн бодлогоо цохон хөндөөгүй нь их хачирхалтай. Бид өөрийн цөмийн зэвсэггүй бүс болон энэхүү бодлогоо зөв тайлбарлан ойлгуулах шаардлагатай байсан юм. Одоо бол АНУ-тай байгуулсан Иж бүрэн түншлэлийн харилцаагаа хэрхэн яаж урагшлуулан хөгжүүлэх вэ гэдэг нь бидний том сорилт хэвээр үлдэж байгаа юм. Ер нь бол стратегийн түншлэл нь урт удаан хугацаанд үргэлжилдэг. Тэгэхлээр бид АНУ-ын шинэ засгийн газартай харилцаагаа өргөжүүлэх хэрэгтэй.

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ

1. “Ардын эрх”. 1990.07.27
2. ГХТА. Ф.108. Т.53
3. James A. Baker. The Politics of Diplomacy: Revolution, War & Peace. Boston., 1995, p.116
4. Х.Олзвой. “Ж.Бейкерийн айлчлал хийгээд «гуравдагч хөрш»-ийн асуудалд”-“Олон улсын харилцаа” сэтгүүл, МУИС, ОУХС, Vol. 184 (5) 2002№1, 166-167 дахь тал
5. “Ардын эрх”. 1998.05.04
6. Монгол Улс-АНУ-ын Хамтарсан Мэдэгдэл. “Гадаад Харилцаа” ГХЯ-ны мэдээллийн товхимол. 2004. 07.30
7. “Өнөөдөр”. 2005.11.24
8. Мөн тэнд
9. Owen Lattimore. The Solution in Asia. Boston.: 1949, p. 226
10. “US Secretary of State John Kerry hails Mongolia as «oasis of democracy» in tough neighbourhood”- The Straits Times. Asia. June 5, 2016

11. Secretary Kerry's Conversation With Young Leaders, Remarks John Kerry Secretary of State, Shangri La Hotel, Ulaanbaatar. Mongolia, June 5, 2016, Embassy of the US, Ulaanbaatar.: Mongolia

В.Энхболд: Өмнөх илтгэгчид, сая Ц.Баатар гуайн илтгэлд хоёр орны харилцаанд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нэн чухлаар тавигдаж байгаа, ийм байх ёстойг тодорхой хэллээ. АНУ дэлхийн хамгийн том эдийн засагтай улс. Өнөөдөр дэлхийд импортоор 1-р байранд, экспортоороо Хятадын дараа 2-р байранд явж байгаа маш том зах зээл. Манай орны хувьд, Америк эхний 10-г ордог худалдааны түнш, харин бид америкийн хувьд 160-170-ын хооронд жагсаалтад бичигдэж байгаа. Хоёр орны хооронд худалдаа, эдийн засгийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн хэд хэдэн баримт бичиг байгуулагдсан. Тухайлбал, 1993 онд Худалдааны харилцааны хэлэлцээр, 1994 онд Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хэлэлцээр, 2004 онд Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр, 2013 онд гарын үсэг зурсан Олон улсын худалдаа хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлын тухай хоёр орны хоорондын хэлэлцээр 2017 оны 3 дугаар сарын 20-нд хүчин төгөлдөр болох гэж байна. Энэ нь худалдаа, бизнес эрхлэх таатай боломж байгаа гэсэн үг. Америк бол Монгол Улсын зах зээлийн харилцаанд шилжих үеэс эхлэн тууштай дэмжиж ирсэн орон. 1990-ээд оны эхнээс Монголд орж ирсэн Америкийн худалдаачид, хөрөнгө оруулагчид бол өнөөдрийг хүртэл манай улсад тогтвортой байгаа бизнес эрхлэгчид. Хэдийгээр бид хууль эрх зүйн хувьд тогтворгүй байсан ч гэсэн энэ түншүүд маань тогтвортой байсан юм аа гэдгийг хэлэх нь зүйтэй юм.

“Амикал”, “Мон-Форте кашмер” зэрэг ноолуурын үйлдвэр, “Caterpillar”-аар анх орж ирээд “Вагнер Ази Тоног Төхөөрөмж” ХХК болсон машин тоног төхөөрөмж, 2010 оны үеэр манай эдийн засаг сэргэсэн үед манай томоохон стратегийн төслүүдийг сонирхож, “Rea-body”, улмаар “Coca Cola” орж ирсэн гэх зэргээр Америкийн эдийн засгийн сонирхол хэдийн бий болсон. Улмаар хувийн хэвшлийн дэмждэг Америкийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим, бизнесийг дэмжих зөвлөлүүд байгуулагдаж идэвхтэй ажиллаж байна.

2005 онд хоёр орны хооронд Худалдаа, хөрөнгө оруулалтын

ерөнхий хэлэлцээр буюу бидний нэрлэж заншснаар TIFA байгуулагдсан. Энэ хэлэлцээр бол үндсэндээ чөлөөт худалдааны суурь хэлэлцээр. Хэлэлцээрийн заалтын дагуу зөвлөлдөх механизмаа байгуулаад 2008 он хүртэл 4 удаа Улаанбаатар болон Вашингтонд хуралдсан. Үүнээс хойш зогсонги байж байгаад одооноос сэргэж байгаа байдалтай байна.

Америк манай улсад хөрөнгө оруулагчдын эхний эгнээнд байнга явж байгаа. 2011-2012 онууд бол Монгол Улсын хувьд маш их өсөлттэй, хөрөнгө оруулагч татсан онууд байсан. Энэ үеэр “Peabody” төлөөлөгчийн газраа байгуулж байсан. 2012 онд 127 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн. Сүүлийн 3-4 жил дэлхийн эдийн засгийн байдлаас, зах зээлийн үнэ болон манай засгийн газар олон солигдсонтой холбоотойгоор эдийн засаг маань хямралд орсон учир худалдаа нь ч, хөрөнгө оруулалт нь ч багассан.

Америкийн, Хойд Америкийн хөрөнгө оруулагчид гэхгүйгээр бүх л гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн чухал зүйл бол тогтвортой байдал. Засгийн газрын бодлого, хууль эрх зүйн тогтвортой, нээлтэй байх явдал нь хөрөнгө оруулагчдад маш чухал. Бид одоо тогтвортой байна гэж хөрөнгө оруулагчдад хэлж байгаа. Энэ амлалтаа бид хэрэгжүүлэх ёстой.

Одоо бол Засгийн газар хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх асуудлыг тавьж ажиллаж байна. Засгийн газраас экспортыг төрөлжүүлэх, экспортын бараагаа олшруулах, зах зээлээ тэлэх бодлого барьж байна. Энэ хүрээнд Японтой ЭЗТХ байгуулсан. Өмнөд Солонгостой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах яриа хэлцээ явуулах эсэх талаар хамтарсан судалгаа хийж эхэлсэн. Евро-Азийн эдийн засгийн холбоотой яриа хэлцээ явуулж байна. Ил тод байдлын хэлэлцээр 3 дугаар сард хүчин төгөлдөр болно. Энэ нь Америкийн хөрөнгө оруулалт Монголд орж ирэх баталгаа, итгэлийг лавшруулна. Монгол, Канадын хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах хэлэлцээрт өнгөрсөн оны 9 дүгээр сард Канадын Спикерийг айлчлах үеэр гарын үсэг зурсан. Монгол Улсын импортын бараанаас шаардсан гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой асуудлыг гаалийн тарифын хуулинд нэмэлт өөрчлөлт оруулснаар цэгцэлсэн. Үүнд бизнесийнхэн ихээхэн талархаж байгаа. Өнгөрсөн 12 дугаар сард Монгол Улс ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг соёрхон баталсан. Энэ хэлэлцээрт

нэгдэн орсноор далайд гарцгүй улсад ялангуяа дамжин өнгөрөх асуудлыг хөнгөвчлөхөд давуу боломж олгож байгаа юм.

Ц.Баатар доктор хувийн хэвшлийнхнийг дэмжих ажил маш чухал гэж хэллээ. Тиймээс манай экспортлогчдыг дэмжихэд Америкийн зах зээл рүү гардаг томоохон экспо, арга хэмжээнд оролцоход Засгийн газар хамтран оролцох, АНУ-ын Засгийн газраас Монголд хэрэгжүүлж байгаа, эсвэл олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа энэ олон төслийг энэ экспортын бүтээгдэхүүнүүдийг экспод аваачихад дэмждэг ийм бодитой дэмжлэг хэрэгтэй байгаа гэж үзнэ.

Америктай хийх худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь ямар чухал болохыг 2015 оны статистикаас харж болно. Жишээ нь манай экспортын 88 хувь нь өмнөд хөрш рүү гарснаас үзэхэд үлдсэн 10 гаруй хувь худалдааны бусад түншид ногдох жишээтэй. 150 улстай худалдаа хийсэн гэж үзэхэд 149 оронд нь 10 хувь нь үлдэж байна.

Д.Ариунболд (УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны зөвлөх): И.Батболд хурандаа илтгэлдээ Монгол, Америкийн батлан хамгаалах харилцааны түүх, энхийг сахиулах чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажилласан тухай, цаашдын төлвийн талаар тодорхой тайлбарлаж тусгажээ. Би байр сууриа судлаач хүний хувьд ярьж байгаагаа тэмдэглэе. Батлан хамгаалахын салбарт Америктай явуулж байгаа харилцаа бол хоёр орны харилцаанд тэргүүлэх байр суурь эзэлж байна. Батлан хамгаалах харилцаа нь бусад салбарын харилцааг хөгжүүлэхэд ч дэмжлэг болдог. Жишээ нь энхийг сахиулах үйл ажиллагаанд АНУ-тай хамтран ажилласнаар манай улсад АНУ-ын хөрөнгө оруулалт татах, тодорхой хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлсэн гэж үздэг. Батлан хамгаалах салбарын зүгээс ярихад бол АНУ-ын ашиг сонирхол манай улсад байгаа гэдгийг хүлээн зөвшөөрнө. Бид геополитикийн хувьд АНУ-ын хувьд чухал байж болох байрлалтай, ОХУ болон БНХАУ-ын хооронд оршдог. Мөн Зүүн Хойд Азийн (ЗХА) аюулгүй байдлыг хангах АНУ-ын үйл ажиллагаанд Монгол Улс идэвхтэй оролцдог учир батлан хамгаалах салбарын харилцаанд хамтран ажиллах өргөн сонирхол байна гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ харилцаа нь мэдээж Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлж байгаа. Ялангуяа гуравдагч хөршийн бодлогод батлан хамгаалахын

харилцаа чухал нөлөө, түлхэц өгч явдаг. ЗХА-ийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд илүүтэйгээр оролцох нь манай улсын аюулгүй байдалд эерэгээр нөлөөлж байна гэж бодож байна. Батлан хамгаалах салбарын хүрээнд ярихад бол цаашдаа анхаарах хэд хэдэн асуудлууд байгаа. АНУ-ын засаг захиргаа шинэчлэгдээд удаагүй байна. Энэ орны батлан хамгаалахын салбарын чиглэл яаж өөрчлөгдөх, хаашаа эргэхийг судлаачийн зүгээс бид анхааралтай судлан үзэх ёстой байгаа. Үүн дээр дөрөөлөөд Монгол, Америкийн батлан хамгаалахын харилцаа цаашдаа яаж өөрчлөлт орох, ямар шинэ арга зам хөгжүүлэх зэргийг боловсруулан судлах ёстой байгаа. Хувь хүний зүгээс харахад урьд өгсөн тусламж, дэмжлэгийн хэмжээ буурахгүй байх гэж үзэж байна. Одоогийн хүрсэн түвшин дээр дүн шинжилгээ хийж үзэхэд АНУ-ын Ази, Номхон далай руу чиглэсэн бодлогод өөрчлөлт гарсан ч энэ нь манай улс АНУ-ын харилцаанд төдийлөн өөрчлөлт авчрахгүй гэж үзэж байна. Мөн судлаачийн зүгээс үзэхэд манай хоёр улсын хоорондын харилцааг хөгжүүлэхэд анхаарах зүйлс бас байдаг.

Хоёр тал батлан хамгаалах салбарын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 1996 онд байгуулсан тухай И.Батболдын илтгэлд гарлаа. Энэ хэлэлцээр бол манай үндсэн суурь хэлэлцээр. Энэхүү хэлэлцээрийг шинэчлэн байгуулах шаардлага байна уу даа гэж үзэж байна. Яагаад гэвэл өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд харилцаа шинэ өндөр түвшинд гарсан. Улс төр, аюулгүй байдлын нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж байна. Гэхдээ үүнийг нарийн судалгаа шинжилгээтэй, Монгол Улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг сайн судалсны үндсэн дээр хийх шаардлагатай.

Мөн “Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх 2015 он” хөтөлбөр хэрэгжээд дууссан байгаа. Хөтөлбөрийн нэг гол заалт болох энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадварыг сайжруулах гэсэн зорилт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн. Энэ зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд АНУ-ын тусламж дэмжлэг чухал үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын хэмжээнд “Төрийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр 2030” гэсэн хөтөлбөр өргөн баригдаж, хэлэлцэх шатандаа явж байна. Бид энэхүү хөтөлбөрт тусгасан зорилтуудаа хангахын тулд АНУ-тай тогтоосон цэргийн харилцаа, тусламжаа зохистой уялдуулах, ямар төрлийн тусламж авах,

хэрхэн хамтран ажиллах тухайгаа төлөвлөх шаардлагатай гэж харж байна. Монгол, Америкийн батлан хамгаалахын харилцаа жилээр төлөвлөгддөг, үүнийг 2-3 жилээр төлөвлөвөл хоёр талдаа ашигтай мэт. Энэ нь санхүү, хөрөнгө оруулалттай холбогдох учраас нэн хэрэгтэй.

Зөвхөн зэвсэгт хүчинтэй биш, гамшигаас сэргийлэх, онцгой байдлын салбарт бид мөн хамтран ажилладаг. Энэ үйл ажиллагаа 2-3 жилийн өмнөөс эхлээд тодорхой үр ахицтай явж байгаа, гэхдээ үүнийг улам өргөжүүлэх шаардлага байгаа болов уу. Ялангуяа Улсын Их Хурлаар хэлэлцэх гэж байгаа хуульд онцгой байдлын байгууллага олон улсын эрэн хайх үйл ажиллагаанд оролцох тусгай багтай болох зорилго тавигдаж байгаа. Энэ хүрээнд бид АНУ-тай хамтран энэхүү багийг байгуулах, Ази, Номхон далайн хэмжээнд гамшиг учрахад энэхүү багаа явуулах, оролцох тийм бололцоо, боломжийг бүрдүүлэх талаар хамтран ажиллах шаардлага байгаа гэж харж байна.

АНУ-ын тусламж, ялангуяа боловсролын “IMET” хөтөлбөрийн хүрээнд өгч байгаа тусламж өсч байгаа. Мөн техникийн чиглэлээр өгч байгаа тусламжийн хэмжээ тогтвортой байна. Иймд бид тусламжийн ашиглалт, төрлийг төлөвлөлтөд тусгаж явах ёстой. Бидний авч байгаа тусламж их хэрэгтэй байгаа ч манай тал том том машин техникүүд авчихсан байгаа нь цаашдаа хангалтын асуудал үүсгэж болох талтайг анхаарч, хүсэлт гаргах хэрэгтэй.

Эцэст нь тэмдэглэхэд манай хоёр орны харилцаанд батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа чухал бар суурь эзэлж, энэ хүрээнд Монгол Улсын цэргийн шинэчлэлийн бодлого урагштай явж ирэв. Манай цэргийн албан хаагчдын мэдлэг боловсрол, албандаа хандах хандлага үүнийг дагаад өөрчлөгдөж, шинэчлэлийн бодлогод сайнаар нөлөөлж байна. Батлан хамгаалах салбар цаашид улам өргөжин хөгжинө гэдэгт итгэлтэй байна.

Ц.Гомбосүрэн: Монгол, Америкийн харилцаа өнгөрсөн 30 жилд үнэхээр баялаг агуулгатай болсон юм байна. Манай илтгэгч нар сонин сайхан, нэгдсэн мэдээлэл өглөө. Аливаа ойг тэмлэглэхдээ хийснээ нэгтгэх, гол нь шийдэж чадаагүй асуудлуудаа гарган тавьж, шийдэх арга замыг ярилцдаг байсан. Тэр үүднээсээ илтгэл тавьсан нөхдүүд олон чухал санаа хэллээ. Нэг бодууштай санаа одоо ч биш нилээд хэдэн жил яригдаж байгаа юм. Энэ бол Монгол, Америкийн харилцааны

материаллаг үндсийг нь бататгах тухай асуудал. Бүр 1990-ээд оноос тавьсан зорилго. Бататгахын тулд бодлогоор дэмжих ёстой. Энэ бодлогоор дэмжих гэдэг үг нэг л задарч, бодит агуулгатай болохгүй байгаа юм шиг санагдаад байдаг юм. Би захиргаадалтын үеийн хүн болохоор тендер, үнийн санал гэдэг зүйлийг яриахаасаа ч өмнө бодлогоо тавих ёстой гэж боддог. Тэгж байж Япон, Америк, Өмнөд Солонгос юм уу Австрали, Канадын сонирхлыг, тэр материаллаг харилцааны үндсийг бодитой болгох ёстой гэж ярьсаар ирсэн. Хүмүүс энэ тухай бишгүй ярьдаг боловч хэрэг дээрээ болохоор олон улсын дүрэм, норм гэдгийг л хардаг юм шиг байгаа юм. Тэр бол нэг талаас зүйтэй л байх, харин Америкийн ч юмуу ямар нэг компанийг оруулна гэсэн бодлого байгаа л юм бол тэрэндээ жич оноо өгч байх ёстой гэж санагдах юм.

Жишээ нь, “Peabody” компанийн гашуун сургамж байна. Дэлхийн нүүрсний энэ том компани манай хаалгыг бараг 10-аад жил нүдсэн байх. Төлөөлөгчийн газраа байгуулсан, судлаад л байсан. Байгаль орчныг тордох талаар сурталчилгаа явуулаад л байсан. Манайхан огт тоохгүй байсаар буцахаас өөр аргагүй болсон байх. Тэгээд нөгөө бодлого маань хаана байна гэхээр байхгүй, тендер ярих юм бол тэд ерөөсөө байр эзлэхээргүй юм ярьдаг бололтой. Тэгэхээр миний хэлэх зүйл бол Америк, Япон, тэр зүгээс явж байгаа компаниудад шууд 100 оноо өг. Хэрвээ 200, 300 оноогоор уралдана гэвэл шууд 100 оноотой байх жишээтэй. Тэгэхгүй бол бодлогоор дэмжинэ гэдэг зүйл ерөөсөө байхгүй байна. АНУ-ын Дэд Ерөнхийлөгч манай тэр том компаниудыг дэмжээрэй гэж л хэлэх гэсэн байх гэж би бодож байна. Гэтэл нөгөө бодлогоор дэмжих ёстой шийдвэр гаргагчид дорвитой юм хийгээгүй.

Тийм учраас энэ 30 жилээс бидний авах сургамж бол хоёр орны харилцааны материаллаг суурийг бэхжүүлэх, бодлогоор дэмжих, бодлогоор дэмжих гэх энэ үгийг задалж хэрэгжүүлэх ёстой гэж бодож байна. Өнөөдөр биднийг баярлуулж байгаа юм бол өнгөрсөн 30 жил үнэхээр амьд агуулгатай бодит харилцаа төлөвшөөд цаашид хөгжих суурь тавигдсан байна гэж хүн болгоны илтгэлд гарч байна. Үүнийгээ улам бодитой болгох үүднээс дахин хэлэхэд бодлогоор дэмжих гэдэг үгийг амьд ойлголт болгож хэрэгжүүлэхсэн гэж хүсч явдгаа хэлье. Энэ 30 жилийн ойн хурлаас ямар нэгэн шийдвэр гарах бол бодлого

боловсруулдаг хүмүүст очдог байх учиртай.

Д. Даваасүрэн: Өнөөдрийн хуралдаанаар Монгол, Америкийн харилцаанд дүн шинжилгээ өгсөн, олон сайхан, ирээдүй рүү харсан санал санаачлагыг манай илтгэгчид, үг хэлсэн хүмүүс гаргаж байна.

Х.Бэхбат сайд илтгэлдээ стратегийн түншлэлийн хүрээнд харилцаагаа хөгжүүлэх урьдчилсан нөхцөл бүрдсэнийг тэмдэглэлээ.

В.Энхболд дарга худалдаа, хөрөнгө оруулалтын эрхзүйн орчноо удаан хугацаанд тогтвортой хадагалахын чухлыг онцоллоо.

Ц.Баатар доктор бид аль салбарт илүү хамтран ажиллах тухай тодорхой ярилаа. Энэ бол сэргээгдэх эрчим хүч. Монгол сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй, нар, салхины эрчим хүч үйлдвэрлэх өндөр боломжтой. АНУ-ын бодлого нь Зүүн Хойд Азийн эрчим хүчний сүлжээнд өөрийн геополитикийн байр сууриа бэхжүүлэх, үүгээрээ дамжуулаад геополитикийн нөлөөний бодлогоо явуулах гэдэг нь стратегийн төлөвлөгөөндөө тодорхой байдаг.

Хурандаа И.Батболд илтгэлдээ, Д.Ариунболд, Ч.Сосорбарам генералын үгэнд батлан хамгаалахын хамтын ажиллагааны асуудлууд нарийн яригдлаа. Харилцааг урагшлуулахад сайн хөшүүрэг болж байна.

Д.Уламбаяр доктор гуравдагч хөршийн тухай эрдэмтэн судлаачид эргэцүүлэн хэлэлцсээр ирсэн тухай ярьлаа. Гуравдагч хөршийн бодлогыг урагшлуулах биежүүлэх ажлыг эхлүүлж, хэрэгжүүлж ирсэн манай 1990-ээд оны ахмад дипломатууд өнөөдөр манай хурал дээр сууж байна. Онолын хувьд, улс орныхоо язгуур эрх ашгийг дээдлэх, дэлхийн хоёр их гүрний дунд оршдог манай орон тэдэнтэйгээ сайн хөршийн нягт хамтын ажиллагаа явуулахын зэрэгцээ дэлхийн бусад тэргүүлэх гүрнүүдтэй тэнцвэртэй сайн харилцах л чин зорилгыг эрмэлзэж гаргасан хэрэг. Энэ концепцийг бид Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа нарийн тусгасан. Тэгэхээр Монгол Улс бол гуравдагч хөршийн үзэл баримтлалтай улс мөн. Энэ бол олон улсын харилцаанд манай гаргаж ирсэн бодлого гэж үзэх нь зүйтэй. Түүхийн үүднээс ч авч үзсэн манай улс 1911 оноос энэ бодлогыг идэвхтэй эхлүүлж байсан. Эдийн засгийн харилцаагаа материаллаг болгох, үүний тулд бодлогоор дэмжих зорилтоо задлах том үүрэг байгааг Ц.Гомбосүрэн сайд тов тодорхой хэлж байна. Энэ нь

манай гуравдагч хөршүүдтэйгээ харилцах том гарц болох юм.

Ү.Бүдсүрэн докторын хэлснээр ардын дипломат ажиллагаа тасралтгүй үргэлжилж, боловсролын салбар, хүмүүнлэгийн салбарт эрчимжиж байна.

Нөгөөтэйгүүр бид үг, үйлдэл, хариуцлагаа дээшлүүлэх учиртайг чухалчлан ярилцлаа.

30 жилийн харилцаа, иж бүрэн түншлэлийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж стратегийн түншлэлд хүргэх үүргийг манай Засгийн газар хэрэгжүүлэх ёстой гэсэн дүгнэлтэд хүрч байна. Энэ стратегийн түншлэлд хүрэхийн тулд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай, ер нь гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих ёстой гэсэн дүгнэлт гарч ирж байна.

Өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хурал үр дүнтэй боллоо. Энэ харилцааг өөрсдөө эхлүүлж, хэрэгжүүлж явсан ахмад дипломатууд, манай дипломат ажилтнууд, эрдэмтэн судлаачид, залуусын өргөн төлөөлөл оролцсон нь бидний ирээдүй рүү чиглэсэн бодлогоо боловсруулахад чухал ач холбогдлоо өгнө гэж дүгнэж байна.

* * *